



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 1168

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын
14 дүгээр сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2023 оны А/15 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 40,075,230.00 (дөчин сая далан таван мянга хоёр зуун гучин) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан ном, сурах бичгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 14 дүгээр сургууль (Э.Гунгаажав)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 28282 ширхэг нийт 40,075,230.00 (дөчин сая далан таван мянга хоёр зуун гучин) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий ном, сурах бичгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 14 дүгээр сургууль (Э.Гунгаажав)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *В.Оюумаа* В.ОЮУМАА



1150500277

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 160 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн ерөнхий боловсролын 14 дүгээр сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн хурлын дүгнэлт	Байгууллагын үнийн санал	НӨХГ-ийн мэргэжилтний үнийн санал	ҮХХХК-ийн хурлын шийдвэр
1	Ном, сурах бичиг	5-19	ш	28282		40,075,230.00		40,075,230.00	ашиглалтын шаардлага хангахгүй болсон	актлах	актлах	устгах	устгах
	Номын фонд			28282		40,075,230.00		40,075,230.00					
	Үүнээс: Худалдах хөрөнгө												
	Актлах хөрөнгө												
	Татан төвлөрүүлэх хөрөнгө												
	Худалдсанаас олох орлого												
	НӨХГ-т төвлөрүүлэх 30%												